



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/525

Хэрлэн сум

Хээрийн дадлага сургууль
зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.3.11.3, 4.3.14.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх мэргэжлийн ур чадварыг сайжруулах зорилгоор Онцгой байдлын газрын жолооч-холбоочин, аврагч-гал сөнөөгч нарт хээрийн дадлага сургууль зохион байгуулсугай.

2.Хээрийн дадлага сургуульд шаардагдах 1,868,635 (нэг сая найман зуун жаран найман мянга зургаан зуун гучин таван) төгрөгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Ард иргэдэд гамшиг ослоос аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлан таниулах, алба хаагчдын хээрийн дадлага сургуулийг чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Онцгой байдлын газрын дарга (Хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 10 дугаар сарын 12-ны
A/525 дугаар захирамжийн хавсралт

ХЭЭРИЙН ДАДЛАГА СУРГУУЛИЛТАД ШААРДАГДАХ ТООЦОО

д/д	Очих газрын чиглэл, маршрут	Материал	Хоол	Нийт зардал
1	Чингис хот – Булган уул – Чингис хот ирж очих 100 км - 20 л, Чингис хот – Дуутын даваа – Чингис хот 160 км-т ирж очих 52 л 123.240 төгрөг	Автомашины хуучин кузов 500,000 төгрөг	40 алба хаагчдын 2 өдрийн хоолны зардал 500.000 төгрөг	1.123.240
	Чингис хот – Тахилга тосгон – Чингис хот ирж очиход 100 км-т 18 л, эрэн хайх аврах ажиллагаа 50 км -9*2- 18 л / 3 автомашин /А-80/-44685, /АИ-92/- 49005, /ДТ/-51705 нийт 145.395 төгрөг		46 алба хаагчдын 2 өдрийн хоолны зардал 600.000 төгрөг	745.395
Нийт – 1.868.635 төгрөг				